

SMITTSKYDDSBALAD

Patientinformation

Hepatit B

Översättning till mongoliska

Version 2022-03-15

Гепатит В, өвчтөний мэдээлэл ба дагах дүрэм**Халдвар хамгаалын эмч нарын халдвар хамгааллын тухай хуудас.****Та яагаад энэ мэдээллийг авсан бэ?**

Цусны шинжилгээгээр таныг гепатит В-тэй гэдгийг тогтоосон. Энэ хуудсанд гепатит В-ийн талаарх мэдээлэл болон гепатит В-тэй өвчтөнд анхаарах зүйл багтсан болно.

Гепатит В гэж юу вэ?

Гепатит В нь элэг, цус болон биеийн зарим шингэнд (жишээлбэл эр бэлгийн эсэнд) илэрдэг вирус юм. Гепатит В-г мэдэхгүйгээр удаан явж болно. Гепатит В нь шинж тэмдэг илрээгүй мөртлөө маш халдвартай байж болно. Тус халдвар авснаас хойш олон жилийн дараа элэгний асуудал үүсч болно.

Гепатит В-гээр хэрхэн халдварлах вэ?

Гепатит В-ийн халдвартай хүн олон бий. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага / ДЭМБ - ын 2019 оны тоо баримтаар дэлхий даяар 300 сая орчим хүн гепатит В-тэй. Ихэнх хүмүүс төрөхдөө эхээсээ халдвар авсан байдаг.

Гепатит В нь мөн бэлгэвчгүй хавьталд ороход халдварлана. Үтрээгээр эсвэл шулуун гэдсээр хамгаалалтгүй бэлгийн хавьталд орох, мөн зарим үед аман сексийн үед гепатит В вирус дамжина.

Гепатит В вирустай цусыг цусаар, эсвэл нүд, хамар, ам гэх мэт салст бүрхэвчээр, эсвэл нээлттэй шархаар дамжуулан авбал гепатит В-гээр халдварлана. Мансууруулах бодис хэрэглэдэг хүн тариур, холигч аяга эсвэл бусад хэрэгслийг бусадтай хуваалцвал мөн халдварлана.

Гепатит В нь найз нөхөдтэйгөө харилцах үед буюу жишээ нь тэврэлт, үнсэлт эсвэл шилэн аяга / таваг / халбага сэрээ хуваалцаж хэрэглэхэд халдварлахгүй. Гэмтээгүй арьсанд цус хүрэх эсвэл нэг 0-ийн өрөө хэрэглэснээр халдварлахгүй.

Бусдад халдварлахгүйн тулд би юуг анхаарах ёстой вэ?

Та эмчийн зааж өгсөн дагах дүрмийг сахих ёстой:

- Эмч таныг давтан үзлэгт дуудсан бол очих ёстой.
- Бэлгийн хавьталд орох хүндээ гепатит В-тэй гэдгээ та хэлэх ёстой.
- Хэрэв таны хамтрагч дархлаагүй буюу гепатит В-ийн халдвар авч байгаагүй эсвэл В вирусын вакцин хийлгээгүй бол та түүнтэй бэлгийн хавьталд орохдоо хамгаалалт / бэлгэвч хэрэглэх ёстой.
- Шүдний болон эмнэлгийн тусламж үзүүлэх үед танаас дээж авах эсвэл танд мэс засал хийх бол та өөрийгөө “цусны халдвар”-тай гэдгийг хэлэх ёстой.
- Шивээс хийлгэх, арьс, чих цоолох болон арьсанд цус алдаж болзошгүй бусад эмчилгээний үед "цусны халдвар"-тай тухайгаа хэлэх ёстой.
- Сахлын хутга, шүдний сойзоо хэн нэгэнтэй нь бүү хуваалц.
- Хэрэв таны цус хэн нэгний арьсны шархлаа, нүд, хамар эсвэл аманд хүрсэн тохиолдолд уг цус гепатит В-ийн халдвартай тухай хэлэх ёстой ба тэрхүү хэсгийг яаралтай усаар зайлахыг шамдуулах. Тэр хүн гепатит В-ийн үнэгүй вакцин түргэн хийлгэх хэрэгтэй ба ингэхийн тулд тэрээр эрүүл мэндийн төв, хамгийн ойр байрлах халдварын эмнэлэг эсвэл 1177 буюу Эрүүл мэндийн хөтөчтэй дариу холбоо барих хэрэгтэй.

SMITTSKYDD SKÅNE

040-33 71 80



- Та тариур, зүү хэрэглэдэг бол тэрийгээ бусадтай бүү хуваалц. Та мөн холигч аяга болон бусад дагалдах хэрэгслээ хуваалцаж ашиглаж болохгүй.
- Та цус, үрийн шингэн, өндөгөө бусдад хандивлаж болохгүй.
- Зарим тохиолдолд эрхтэн, эд эсийг шилжүүлэн суулгах зорилгоор хандивлах боломжтой.
- Танд гепатит В-ийн вакцин хийлгэх шаардлагатай бэлгийн хамтрагч эсвэл гэр бүлийн гишүүн бий бол эмчдээ хэлэх.

Бусдад халдварлахгүйн тулд дагаж мөрдөх **эрүүл ахуйн зөвлөмж** гэж бас байдаг:

- Бүх шархандаа наалт наасан эсэхийг шалга.
- Шархны боолт хийхэд тань туслах хүн хуванцар бээлий өмсөх хэрэгтэй.
- Цустай материалыг хаяхын өмнө сайтар савла.
- Хувцас тань цустсан бол угаалгын машинд угааж болно.
- Шалан дээрх цусны толбыг жишээ нь цаасаар арчиж хаяж болно. Дараа нь ус, цэвэрлэх бодисоор сайтар угаа.

Би хамтрагчтайгаа бэлгийн хавьталд орохын өмнө юуг анхаарах ёстой вэ?

Та хамтрагчдаа гепатит В-тэй тухайгаа хэлэх ёстой. Таны хамтрагч дархлаагүй (өөрөөр хэлбэл, гепатит В-ээр халдварлаагүй эсвэл гепатит В-ийн вакцин хийлгээгүй) бол та бэлгэвч хэрэглэх ёстой.

Та бэлгийн хавьталд орохын өмнө хамтрагчтайгаа эмчид/хүлээн авах руу очиж, гепатит В-ийн үнэгүй вакцин хийлгэх нь хамгийн зохистой.

Та вакцин хийлгээгүй хүнтэй бэлгэвчгүйгээр хавьтаж түүнийг халдварлах эрсдэлд оруулсан бол халдварлах эрсдлийг бууруулахын тулд дараа нь үнэгүй вакцин хийлгэж болно.

Вакциныг хоёр хоногийн дотор хийж чадвал хамгийн сайн нөлөөтэй.

Би хэр олон удаа эмчийн үзлэгт орох шаардлагатай вэ?

Таныг хэр олон удаа давтан үзлэгт ирэхийг эмч шийднэ. Ихэнхдээ жилд нэг удаа байх ч заримдаа илүү олон удаа очих шаардлагатай болж болно.

Гепатит В-тэй байх нь аюултай юу?

Гепатит В-тэй ихэнх хүн элэгний асуудалд хэзээ ч орохгүй, гэхдээ зарим нь олон жил халдвартай явсаны улмаас өвчилж болно. Асуудалд орсон хүн хамгийн муу тохиолдолд элэгний хатуурал эсвэл элэгний хорт хавдар тусч болно.

Та эмчид тогтмол үзүүлэх ёстой ба үзлэгийн үед таны элгийг ямар байгааг шалгаж, шаардлагатай бол эмчилгээ хийнэ.

Гепатит В-гийн эмчилгээ хийх үү?

Шаардлагатай бол танд эмчилгээ хийнэ. Ихэнх хүмүүст эмчилгээ хийх шаардлагагүй. Танд эмчилгээ шаардлагатай эсэхийг эмч хэлж чадна.

Эмчилгээ нь ихэнхдээ халдварыг эмчлэх, арилгах боломжгүй ч, хойшид элэгний асуудал үүсэх эрсдлийг бууруулах боломжтой.

Би эцэг эх болж чадах уу?

Чадна, гепатит В нь хүүхэд төрүүлэх эсвэл эцэг эх болоход саад болохгүй. Гэхдээ хүүхэдтэй болохоос өмнө таны бэлгийн хамтрагч гепатит В-ийн дархлаатай болох нь чухал (жишээ нь вакцин хийлгэх аргаар).

Та жирэмсэн болсон бол, гепатит В вирусыг хүүхдэд шилжүүлэхээс сэргийлэх арга бий.

Заримдаа жирэмсний төгсгөлд гепатит В-ийн эмчилгээ хийлгэж болно. Хүүхэд төрсний дараа нэн даруй гепатит В-ийн вакцин хийж, дараа нь эхний жилд нь хэд хэдэн удаа нэмэлт тунгаар вакцин хийнэ. Ингэснээр хүүхэд гепатит В-ээр халдварлах эрсдэл маш бага болно. Хүүхдэд төлөвлөсний дагуу вакцин хийсэн бол, түүнийг ердийнхөөр хөхүүлж болно.

SMITTSKYDD SKÅNE

040–33 71 80



Би дурын ажил хийж, дурын аргаар чөлөөт цагаа өнгөрөөж болох уу?

Гепатит В-тэй үед ерөнхийдөө ямар ч ажил хийж болно. Хэрэв та ажил дээрээ өөрийгөө хатгаж, улмаар таны цус өөр хүнд хүрэх эрсдэлтэй бол эмчид ханд. Хэрэв та өөрийгөө тодорхой мэргэжлээр сурч болох эсэхдээ эргэлзэж байгаа бол мөн адил эмчид ханд. Та ажил олгогчдоо гепатит В-тэй гэдгээ хэлэх шаардлагагүй.

Хэрэв та цус алдах магадлалтай спортоор хичээллэхийг хүсч байвал тэр тухай эмчтэйгээ ярилц. Хичээллэх нь зөв эсэхийг эмч шийдэж чадна.

Гепатит В нь Халдвар хамгааллын хуулиар зохицуулагддаг - энэ юу гэсэн үг вэ?

Халдвар хамгааллын хууль нь зарим халдвар буюу, жишээлбэл гепатит В илүү олон хүнд халдварлахыг бууруулах зорилготой.

Та гепатит В-тэй бол энэ халдвартай холбоотой эмчилгээ, үйлчилгээ үнэ төлбөргүй хийлгэх эрхтэй.

Та эмчийн зааж өгсөн дагах дүрмийг сахих ёстой. Та мөн халдварын мөрдөлтөнд туслах ёстой.

Хэрэв та хүлээн авсан дагах дүрмээ буруу гэж үзэж байгаа бол өөрийн бүс нутаг / аймгийн халдвар хамгааллын эмчтэй холбоо барьж болно. Таны гомдлыг шийдвэрлэж дуустал та хүлээн авсан дүрмээ дагаж мөрдөх ёстой.

Халдвар мөрдөлт - энэ юу гэсэн үг вэ?

Гепатит В-тэй бусад хүмүүсийг илрүүлэх нь маш чухал, ингэснээр нэгд тэр хүмүүс элэгний хяналтанд орох боломжтой, хоёрт халдвар бусдад тархахаас сэргийлнэ. Тиймд хэрэв та гепатит В-тэй бол хэнтэй бэлгийн хавьталд орсон, эсвэл хэнийг тус вирусаар халдварлах эрсдэлд оруулсан бол (жишээ нь тариур, зүү хуваалцсан бол) эмчдээ мэдэгдэх ёстой, ингэснээр тэд гепатит В-ийн шинжилгээ хийлгэх ёстой тухайгаа мэдэж авна. Таны хэлэх зүйл нууцлагдах тул, өөрсдийнх нь тухай хэн хэлснийг тэдгээр хүмүүс мэдэж авах боломжгүй.

Таны гэр бүл болон ах дүүс Шведэд байдаг бол тэднээс гепатит В-ийн шинжилгээ авахыг эмч зохицуулна.

Та нэмэлт мэдээлэл авахыг хүсч байна уу?

Гепатит В-ийн талаарх нэмэлт мэдээлэл дараах хаяг дээр бий:

www.1177.se

www.umo.se

www.folkhalsomyndigheten.se